

## Танилцуулга

### • Үндсэн сургалт

Үндсэн сургалтаараа ЖДҮ эрхлэгчид болон аж ахуйн нэгж байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулж практикт тулгуурласан, ноу-хауг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж ирсэн. Бизнес эрхлэхэд шаардлагатай үндсэн 6 сэдвийг 6 сарын хугацаанд олон жилийн арвин туршлагатай Япон, Монгол багш нар зааж байна. Түүнчлэн аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлаар ганцаарчилсан зөвлөгөөг хэрэгжүүлдэг нь тус сургалтын гол онцлогийн нэг юм.

### • Тусгай сургалт , ахисан түвшний сургалт

Эрэлт хэрэгцээ өндөр, үндсэн сургалтанд тусгагдаагүй тусгай сэдвээр богино хугацаанд ахисан түвшний мэдлэгийг олгодог.

### • Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх оношилгоо, зааварчилгааны хөтөлбөр

Монголын эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж буй дундаас дээш хэмжээний компанийг хөгжүүлэх зорилгоор эрчимтэй зөвлөх үйлчилгээ, оношилгоо зааварчилгааг хэрэгжүүлж байна. Компаний хүсэлтэнд нийцүүлэн үр өгөөжтэй оношилгооны аргачлалыг ашиглаж, хамтын оролцоотой зааварчилгаа, сургалтыг хэрэгжүүлдэг. Хөтөлбөрт хамрагдсан компани нь байгууллагын менежментийн мэдлэг эзэмшээд зогсохгүй жишээ, дасгал ажиллан практикт тулгуурласан ноу-хауг хамтран эзэмшдэгээрээ онцлогтой.

### • Ажлын байран дээрх сургалт

Япон мэргэжилтэн, үндэсний сургагч багш хамтран тухайн байгууллагын хүсэлтэнд тулгуурлан эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулдаг.

## Хичээл заах багш

ЖАЙКА-ийн Япон мэргэжилтэн (монгол орчуулгатай) болон МЯТ-ийн арвин туршлагатай үндэсний сургагч багш нар заана.

## Тараах материал

Сурах бичиг, дасгал ажлын тараах материал болон бусад нэмэлт шаардлагатай сургалтын хэрэгслээр хангана.

## Хичээлийн хуваарь, завсарлага

Хичээл: 13:30-18:00

Завсарлага: 14:50-15:00,16:20-16:40 (кофе, цай, печень, чихэр, алжаал тайлах дасгал)

## Төлбөр, бүртгэлийн журам

Төлбөрийг бэлэн болон бэлэн бусаар төлөх боломжтой. Бэлэн бусаар төлөх тохиолдолд нэхэмжлэх авна. Төлбөр төлөгдсөнөөр бүртгэл баталгаажна. Оролцогч хувийн шалтгаанаас болж оролцож чадахгүй болсон тохиолдолд төлбөр буцааж олгохгүй болно. Сургалтанд бүртгүүлэхийн тулд анкет бөглөх шаардлагатай. Бүртгэлийн анкетийг [www.japan-center.mn](http://www.japan-center.mn) вэб хуудаснаас татаж авна уу.

## Сертификат

5 хоногийн сургалт 70%, 3 хоногийн сургалт 80%-иас дээш ирцтэй оролцогчидод сертификат олгоно.

Сургалт тус бүрийн төгсгөлд санал асуулгын хуудсаар суралцагчидынхаа санал, сэтгэгдлийг хүлээн авч үйл ажиллагаагаа сайжруулахад тусган ажилладаг.

Улаанбаатар хот, Монгол улс  
Монгол-Японы Төвийн байр  
Шуудангийн хайрцаг 46А-190

Утас: 11-310879 (3)  
Факс: 11-317528  
URL:[www.japan-center.mn](http://www.japan-center.mn)  
Email:[mjc@japan-center.mn](mailto:mjc@japan-center.mn)




Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төв

# Бизнесийн сургалтын жилийн хөтөлбөр



14 жилийн туршлага, уламжлал



Таны бизнесийн амжилтыг  
Бид хамт бүтээлцэнэ

Ангилал	Сургалтын сэдэв	2015 он				2016 он						Төлбөр	Хамрагдах хүн
		9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар		
Үндсэн сургалт	Менежментийн стратеги	14-18										600,000₮	Нийт 50 хүн Үйлчилгээний анги 25 хүн Үйлдвэрлэлийн анги 25 хүн
	Маркетинг			23-27									
	Дэлгүүрийн удирдлага		26-30										
	Үйлдвэрлэлийн удирдлага			02-06									
	Санхүүгийн удирдлага				07-11								
Тусгай сургалт	Хүний нөөцийн удирдлага				18-22							180,000₮	30 хүн
	Удирдлагын нягтлан бодох бүртгэл		12-16										
Ахисан түвшний сургалт	Төслийн менежмент						29-3/4					140,000₮ 180,000₮ 140,000₮ 140,000₮	25 хүн
	Үйлчилгээний маркетинг/Брэндинг			30-12/2									
	Бизнесийн харилцаа					18-22							
	Аж ахуй нэгжийн санхүү							21-23					
	Үйлдвэр/Чанарын удирдлага						15-17						
Бусад	Хүний нөөцийн стратеги									27-29	140,000₮	500,000₮-700,000₮	3-5 компани
	Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх оношилгоо, зааварчилгааны хөтөлбөр	Нийт 6 цагаар 6 удаа Сэдвийн хүсэлтэнд нийцүүлэн харилцан ярилцсаны үндсэн дээр шийднэ											
	Ажлын байран дээрх сургалт										Тухайн байгууллагын нийт ажилчдын тооноос хамаарна		

Дээрх сэдвүүдээс гадна 5S сайжруулах үйл ажиллагаа, Бүтээмж, Санхүүгийн шинжилгээ, Манлайлал ба багаар ажиллах, Асуудлыг шийдвэрлэх ба шийдвэр гаргах, Бизнес процессын дахин загварчлал зэрэг болон бусад сэдвийн хүрээнд ажлын байран дээрээ сургалт авах боломжтой

### Сургалтын онцлог, давуу тал



#### Бизнесийн сүлжээгээ өргөжүүлэх

- Бизнесийн хамтрагч, сүлжээгээ өргөжүүлэх боломж
- Харилцан туршлага солилцох боломж
- Японы компанитай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломж
- Байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ шинжилгээ хийж тулгамдаж буй асуудалд тань тохирсон сургалтыг санал болгоно

#### Өөр хаанаас ч олж авахгүй практик ноу-хау

- Олон жилийн арвин дадлага туршлагатай мэргэшсэн сургагч/зөвлөх багш нар
- Японд туршлага судлах дадлага хийх боломж
- Хамтын оролцоонд тулгуурласан онол, дадлагыг хослуулсан шинэлэг арга зүй
- Практикт тулгуурласан сургалтын агуулга, дасгал ажлууд, бодит жишээ

Сургалтын таатай орчин, суралцагч бүрт зориулсан сургалтын материал



#### Цогц дэмжлэг

- Байгууллагад тулгамдаж буй асуудлаар ганцаарчилсан зөвлөгөө өгдөг
- ЖАЙКА-ийн бусад төсөл хөтөлбөрийн талаарх танилцуулга